

Бага Сургууль, олон нийтийн хамтарсан байгууллага
бүртгэгдсэн

БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ СУРГУУЛИЙН ДҮРМҮҮД

1. Сурагчийн эрх ба үүргүүд

Сурагч доорх эрх эдэлнэ:

- Боловсрол, ур чадвар, оюун ухаан ба бие бялдарын чадварыг харгалзаж хувийн зан чанарыг хөгжүүлэх;
- Ёс журмын зарчмуудад нийцсэн зохих хэлбэрээр сургуулийн арга хэмжээний тухай өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж ярилцах, үзэл бодол саналаа зохих хэлбэрээр илэрхийлсэн ба үүнд анхаарал тавьж хөгжүүлэх;
- Үл тэвчил, дайсагнал ба хүчирхийлээс хамгаалагдсан байх;
- Нийгмийн эмгэг харш үзэгдлүүдээс хамгаалагдсан байх;
- Эрүүл орчинд суралцах;
- Амралт ба чөлөөт цагийн эрх;
- Сурлага боловсролынхоо дүн ба явцыг мэдэх мэдээлэлтэй байх;
- Боловсрол сургалтанд хамаарах сургуулийн зөвлөх туслалцаа авах;
- Сургуулийн хамт олноос зөвлөгөө ба туслалцаа гуйх – хэрэв хүүхэд аливаа нэгэн тухгүй байдал ба асуудлуудтай тулгарвал;
- Сургуулийн хүрээнд сурагчдын өөрийгөө удирдах ажлыг явуулах (сурагчдын өөрсдийн удирдлага), санал өгөх ба сонгох сонгогдох, тэдэнтэй хамтран ажиллах ба сургуулийн тэргүүлэх багшид тэднээр дамжуулан хандах, тэргүүлэх багш өөрсдийгөө удирдагчдын санал бодол ба хүсэлтийг хамтран ярилцах хриуцлагыг хүлээнэ.

Сурагчийн үүрэг:

- Сургуулийн Дүрмийг мөрдөх, ялангуяа техникийн ангийн дүрмүүд, сургуулийн клубууд ба сургуулийн гуанзын дүрмүүд, эрүүл мэнд ба аюулгүй байдлын дүрмүүд ба удирдамжийг мөрдөх, зөвхөн сургуульдаа биш харин сургуулиас авах арга хэмжээ болон бусад гадуур үйлдэх арга хэмжээнд сургуулийн дүрмийг мөрдөх (жишээ нь, сургалтын семинарууд, аялал экскурс, спортын арга хэмжээ, уралдаанууд, олимпиад гэх);
- Сургуулийг цэвэр цэгцтэй байлгах ба нямбай сурах;
- Сургагч хамт олон ба бусад сургуулийн хамт олны зааварчилгааг дагах;
- Ангийн хичээлд саад болохгүй байх ба Сургуулийн Дүрмийг ноцтой зөрчсөн тохиолдолд сурагч хувийн зэмлэл хүртэнэ;
- Бичвэрийн дэвтэр ба сургуулийн тусламжийн материалуудтай нямбай хандах, байр болон сургуулийн талбайг эмх цэгцтэй байлгах, эд өмчөө хохиролоос хамгаалах;
- Хамтран суралцагсдынхаа өмч эдийг эвдэхгүй байх, сахилга бат, бие авч явах зарчмыг мөрдөх (сургуулийн хамт олон ба хамтран суралцагчдыгаа үгээр ба биеэр

доромжлох нь хариуцлагын ноцтой зөрчилд тооцогдоно, үүнийг сахилга батын оноог бууруулж шийтгэдэг);

- Сургуулийн багшид эсвэл сургуулийн удирдлагад дээрэлхэл, цахим дээрэлхэл, ялгаварлан гадуурхал ба бусад нийгмийн эмгэг үзэгдэлийн тухай мэдээллэх эсвэл үүнээс сэргийлэх;
- Сургуулийн хуваарийн дагуу тухайн өдөрт хичээлийн ном ба сургуулийн туслах материалуудыг өөртөө авч явах;
- Сургууль ба ангид хориотой болон хүний биеийн ба хүүхэд ба залуучуудын сэтгэл зүйн эрүүл мэндэд уршиг учруулах зүйлс авчрахгүй байх (жишээ нь, гар утас, таблет, зөөврийн электроник хэрэгслүүд, гал гаргах зүйл гэх мэт), сургуулийн болосвролын хөтөлбөртэй (SEP) холбоогүй зүйлс, үүнд үнэ цэнэтэй зүйлс, маш их хэмжээний мөнгө гэх мэт орно. Хэрэв сурагчийн хууль ёсны төлөөлөгч түүнд гар утас, бусад холбооны материалууд эсвэл бичлэгийн тоног төхөөрөмж (цаашид “хувийн хэрэгсэл” гэнэ) авч явахыг зөвшөөрсөн бол сурагч түүнийг унтрааж цүнхэндээ хадгалах үүрэгтэй;
- Сурагчид өөрсдийн хувийн зүйлийг цүнхэндээ хийж цоожлоно. Хэрэв хувийн зүйл нь сайн цоожлогдохгүй бол сурагч хувийнхаа хэрэгслүүдийг өөртөө авч түүнийгээ сургуулийн дүрмийн дагуу хэрэглэнэ. Сурагч үнэ цэнэтэй зүйл болон ихээхэн хэмжээний мөнгийг сургуулийн бичиг хэрэг эрхлэх туслахад хадгалуулах нь зөв;
- Сургууль нь хувийн хэрэгслүүд алдагдах, эвдрэх эсвэл хулгайлагдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй, үүнийг сурагчийн хууль ёсны төлөөлөгч даатгалын компани болон хуулийн зохих байгууллагатай хамтран шийднэ;
- Хэрэв хичээлийн үед хувийн хэрэгслүүдийг хэрэглэхийг хорьсон бол сурагч үүнийг сурган хүмүүжүүлэгчийн хүсэлтээр унтрааж түүний ширээн дээр тавих ёстой. Хичээлийн өмнө ба дараа багш нь түүнд буцааж өгч цүнхэндээ хийх заавар авна;
- Сурган хүмүүжүүлэгчийн заавар мөрдөж дагахгүй байх нь Сургуулийн Дүрмийг ноцтой зөрчсөнд тооцогдох ба сурагчид Боловсролын Актын дагуу арга хэмжээ авна;
- Сурган хүмүүжүүлэх ажилтны зааварчилгааг дагахыг татгалзах нь Сургуулийн Дүрмийг ноцтой зөрчсөнд тооцогдох бөгөөд сурагч нь Боловсролын Актын дагуу сургуулийн сурган хүмүүжүүлэгчийн зааврыг Сургуулийн Дүрмийн хууль зүйн дүрэм буюу сургуулийн дотоод дүрмийг даган мөрдөх ёстой. Багш нь энэ фактыг сурагчийн бичлэгийн дэвтэрт тэмдэглэж, хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэл хийнэ (утсаар, эмейл бичих зэрэг). Энэ дүрмийн зөрчил ба зааварчилгааг дагаагүй байдал нь Сургуулийн Дүрмийг зөрчсөн нэг хэсэг болно;
- ICT хэрэглэж байхдаа сурагчид биеэ хариуцлагатай авч явж, багш ба бусад сургуулийн ажилчидтай хамтран ажиллаж, сургуулийн мэдээлэл ба өгөгдлүүдийг вирус, зөвшөөрөөгүй нэвтрэлт, эвдрэл, буруу ашиглах эсвэл хулгайгаас хамгаалах, бүх сурагчид сургуулийн компьютерийн тогтолцоог хуулиар зааснаар ашиглаж, төхөөрөмжийг боловсрол хичээлдээ хэрэглэж, гэрэл зураг ба дүрст бичлэгүүдийг зөвхөн багшийн эсвэл сургуулийн удирдлагын зөвшөөрөлтэй хэрэглэнэ;
- хичээлдээ няхуур нямбай хандаж цагтаа ирэх ёстой, сурагчийн бичвэрийн дэвтэрээ багшдаа үзүүлэх;

- өвчний дараа сургуульдаа ирсэн бол хичээлийн хуваарийг яаралтай нөхөх, сурагчид үүний талаар багштайгаа зөвлөлдөх эрхтэй;
- өөрийн ба бусад сурагчдын эрүүл мэндийг хамгаалах; тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэх ба мансууруулах бодис хэрэглэх хориглоно, сургууль ба сургуулиас зохион байгуулж байгаа арга хэмжээнд аливаа нэгэн дэр дурьдсан бодисуудын авчрах ба тараах хориотой;
- сургуульд амь насанд аюул учруулж болох зүйл авчрахгүй байх, үүнд ангид шууд хамаагүй гэхдээ бусдын эрүүл мэнд аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх зэвсэг, тэсрэх бодисууд, пиротехник ба бусад ижил зүйл авчрахгүй байх;
- сургуулийн арга хэмжээтэй холбоотой үүссэн аливаа нэгэн гэмтэлийг багш, ангийн багш ба сургуулийн өөр нэгэн ажилчинд **цаг алдалгүй** мэдээллэх ёстой; цаашид удаж мэдээллэсэн тохиолдлуудыг сургууль зөвшөөрөхгүй;
- ном, сургуулийн тусламжийн материалууд ба сургуулийн өмчийг гамнах, үүнд хохирол учруулсан бол сурагчийн төлөөлөгч санхүүгийн болон өөр нэгэн нөхөх өргө хэмжээнд өртөнө;
- сургуульдаа эмх цэгцтэй очих, цаг барих ба цэвэр хувцасласан байх, эрүүл ахуйн дүрмийг дагах, зохих гутал өмсөх, спорт гутал өмсөхгүй байх, гадуур хувцас ба малгайг хувцасны өрөөнд орхих, **ялгаварлан гадуурхсан тэмдэгтэй хувцас өмсөхгүй байх, экстремист байдал ба түүний эрсдэлийн талаар мэдлэгтэй байх;**
- сургуулийн байрыг өглөө ба үдээс хойш хичээлийн үеэр зөвшөөрөлгүй орхиж явах, сурагчид зөвхөн багшийнхаа зөвшөөрөлтэй ба түүний хяналтан дор сургуульд байх ёстой;
- сурагчийг сургуулийн байгууллагын эсрэг байнга давтагдах үгийн ба биеийн халдалт хийх нь ноцтой ба хариуцлагын том алдаа гэж үзэх ба Актын үүргийг зөрчиж байна гэж тооцно. Хэрвээ сурагч эсвэл оюутан энэхүү үйлдэл хийсэн бол тэргүүлэх багш нь дараачийн ажлын өдөр хүүхдийн хууль зүйн ба нийгмийн ажилтанд мэдэгдэх ёстой (өсвөр насны хүүхэд байх тохиолдолд) эсвэл нийтийн прокурорын газар мэдэгдэл хийнэ (насанд хүрсэн хүний тохиолдолд);

Энэ дүрмэнд заасан хариуцлагыг зөрчсөн тохиолдолд зөрчлийн хүндээс шалтгаалж доорх боловсролын арга хэмжээг сурагчид ноогдуулж болно: ангийн багшийн зэмлэл (СТА), ангийн багшийн шүүмжлэл (CTR), тэргүүлэх багшийн шүүмжлэл (HR). Ангилалын хугацаанд (улиралд) сургуулиас арга хэмжээ авч болно. Сургууль оюутанд ба түүний хууль зүйн төлөөлөгчид шүүмжлэл ба зэмлэлийн талаар яаралтай мэдэгдэл хийж, сургуулийн дэвтэрт нь тэмдэглэнэ. Шагнал ба бусад урамшууллын дүрмүүд ба зэмлэл шүүмж гаргах зэрэг нь Сургуулийн Дүрмийн хэсэг ба Ангилалын Хэсэг юм.

2. Хууль ёсны төлөөлөгчийн эрх ба үүрэг

Хууль ёсны төлөөлөгч нь сургуулийн боловсролын үйл ажиллагаанд хамтран ажиллагч мөн. Түүний үүрэг маш чухал ба хүүхдийн тухай бүх мэдээллийг авах бүрэн эрхтэй.

Хууль ёсны төлөөлөгч доорх эрхтэй:

- Хүүхдийнхээ сургуулийн чөлөөт сонголт хийх;
- Хүүхдийнхээ боловсролын явц ба дүнгийн тухай мэдээлэл авах;
- 106/1999 Актын дагуу мэдээлэлд үнэгүй хүрэх, үзэх эрхтэй, өөрчлөлт оруулсны дагуу;
- Боловсролын Актын дагуу сургуулиас зохих боловсрол ба зөвлөх тусламжийн мэдээлэл үйлчилгээ авах;
- Багш ба тэргүүлэх багшаас сургалтын процессийн тухай асуулт гарсан тохиолдолд асуух, санал гаргах;
- Хүүхдийнхээ тухай өөрсдийн бодол шийдвэрийг солилцох, түүний саналд анхаарал хандуулах;
- Сургуулийн зөвлөлд санал өгөх ба сонгогдох;
- Хүүхдийг хичээлээс чөлөөлөхийг хүсэх эсвэл хүсэлт гаргах; энэ хүсэлт нь бичгээр урьдчилан хийгдсэн байх, нэг өдрийн хичээлд ирээгүй байдлыг ангийн багш зөвшөөрнө, олон өдрийн хичээлд ирэхгүй байдлыг тэргүүлэх багш эсвэл орлогч тэргүүлэх багш шийдэх учиртай;
- Сурагчийг дахин шалгалт өгүүлэх хүсэлт гаргах;

Хууль ёсны төлөөлөгчийн үүрэг:

- Сурагчдыг сургуульд хүрэлцэн ирэх ба сургуулийн үйл ажиллагаанд цагтаа няхуур явах байдлыг хангадаг, цэгц бэлтгэлтэй, өвчтэй бус эрүүл байдлыг хангана.
- Сургуулийн Бүртгэлд 561/2004 Актын дагуу 28(2) ба (3) Хэсгийн заалттай зөвшилцөн сургуульд зохих мэдээллийг бүрдүүлж өгөх ба сурагчийн аюулгүй байдал ба хичээлд хэрэгцээтэй бусад мэдээллийг цагт нь эмх цэгцтэй бүрдүүлж өгөх ба энэ мэдээллүүдэд орох өөрчлөлтүүдийн тухай мэдээлж байх;
- Тэргүүлэх багш болон бусад багш нарын шаардлагаар сургуульд ирэх ба сурагчийн боловсролын талаар идэвхтэй ярилцаж байх;
- Сургуулийг сурагчийн эрүүл мэндийн байдалд гарсан өөрчлөлтийн талаар, сурагчийн эрүүл мэндийн асуудлууд ба сурагчийн аюулгүй байдал ба хичээлд нөлөөлөх асуудлуудын тухай бусад ноцтой мэдээллүүдийг цагт нь зайлшгүй хүргэж байх;
- Сургуулийн боловсролын үйл ажиллагаа, жишээ нь сэлэлт, цанаар гулгах, аялалууд, сургуулийн гадуур болох үйл явдал зэрэгт оролцоо талаар мэдээлж байх;
- Сурагчийн хичээлд ирээгүй шалтгааныг ирээгүй өдрөөс тоолон гурван хоногийн дотор утсаар болон цахим шуудангаар тайлбарлаж тэмдэглэж байх;
- Сурагчийн бичгийн дэвтэрт хичээлд ирээгүй шалтгааныг бичгээр тэргүүлэх багшид тайлбарлаж тэмдэглэл хийж байх;
- Сургуульд ирэхдээ сурагчийн тухай сургуулийн офист тайлагнал хийж байх (энэ хариуцлага эцэг эх ба багшийн уулзалт, зөвлөгөөний өдрүүд эсвэл сургуулиас зохион байгуулах арга хэмжээнд хамрахгүй).

1. 9. 20..

Тэргүүлэх багш